



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/184

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээ, зориулалтад
өөрчлөлт оруулж эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Жамбын Цолмонбаатар /РЭ76042019/-ын хүсэлтийг тус тус үндэслэн сумын аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/65 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалтаар Мөрөн сумын 8 дугаар баг 9 дүгээр гудамж 15 тоотод байршилтай 6712017312 нэгж талбарын дугаартай 700м² газрын талбайн хэмжээг 882 м² гэж, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий болгон өөрчилж үлдсэн 28 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/65 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн Жамбын Цолмонбаатартай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН